



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.2.5, 6.4.3, 6.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хэнтий аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2017 оны 22/07/022/96 дугаар дүгнэлтээр цаашид ашиглах боломжгүй болох нь тогтоогдсон 300,000.00 (гурван зуун мянган) төгрөгийн балансын үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хэнтий аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга Д.Баярхүүд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг данснаас хасах, сэлбэг, материал болгон ашиглах, ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Газрыг байгууллагын албан хэрэгцээнд хэвээр үлдээж, нөхөн сэргээх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТЭСНИЙ
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

D:\Huraldaanii material\2018.01.23\togtool\02docx

0001400

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 01 дугаар сарын 2-ны өдрийн
15 дугаар тогтоолын хавсралт

**ХЭНТИЙ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоошир хэг	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Гарааш (шавар, 19.8 м.кв)	1997.10.01	ш	1	300,000.00	300,000.00	0.00
	Дүн				300,000.00	300,000.00	0.00
					(гурван зуун мянган)	(гурван зуун мянган)	